

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Бадамгаравын Тайванбаяр(Лувсан)	Дугаар	L046
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Баяндун
Төрсөн газар	Дорнод аймгийн Баяндун сум	Төрсөн он	1978
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Угтамтэгчинлэн хийд	Сүм хийдийн дугаар	ДОБД 029
Одоогийн сүм хийд	Угтамтэгчинлин хийд	Сүм хийдийн дугаар	ДОБД 030
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 9	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Дорнод аймгийн Баяндун сумын Угтамтэгчинлэн хийд

Манай хийдэд маршал Чойбалсан хүүхэд байхдаа шавилан сууж байсан гэдэг. 8-13 нас хүртлээ л сууж байсан юм шиг байгаа юм. Том лам нар өргөөндөө морилоод сууж байсан чинь гадаа байсан хүүхдүүдээс нэг хүүхэд аягүй муухай бархирсан гэнэ. Нэг ламаа гаргаад харуулсан. Хэн байна? ямар хүүхэд байна гэж. Гарч харсан хүн Чойбалсан байна гэсэн. Тэгсэн наад хүүхэд чинь ирээдүйд бидний толгойг залгих цусан гартай хүүхэд байна. Наадахаа буцаа . Явуул гэж хэлсэн. Тэгээд Чойбалсан ээжтэйгээ хоёулаа явсан. Ээж нь нэг ламын тогооны хүн байсан. Тэгээд л явсан гэсэн.

-Довчин хувилгааны тухай бас хууч яриа байдаг гэсэн. Тэр тухай сонссон дуулснаасаа хуучлаач.

Сан бэйсийн хүрээний ноёны хатан нь өвдөөд эрдэм чадалтай гэсэн болгоныг залж авчраад тус эс олсон гэнэ. Тэгээд Довчин хувилгааныг дуудуулж хоёр элч явуулжээ. Тэгсэн өө зүгээр зүгээр. Би очиж чадахгүй нь. Шинийн 15-нд толгой дээр нь цаасан хүн хийгээд тавьчихаарай . Тэр үед би очье гэжээ. Тэгээд 15 боллоо гэнэ. Довчин

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хувилгааны хий гэснийг хийгээд байж байтал гэрийн гадаа буу дуугарч гэнэ. Гараад хартал юм алга. Орж ирэхэд хатны толгой дээр хийж тавьсан цаасан хүн шатаж байсан. Хатан эв эрүүл болж ,ноён Довчин хувилгаанд шавь орж хийдийн жасад их хөрөнгө өгч байсан гэдэг. Алт, мөнгө, адуу мал их өгсөн гэсэн. Довчин хувилгааны тухай энэ мэтийн олон хууч яриа байдаг. Бөө дарсан тухай бас хэлэлцдэг. Угтамын давааны оройд нэг суварга байсан юм гэнэ лээ. Угтамаас урагш Дунд могойтод айхтар заарин байдаг байжээ. Тэгээд ердөөсөө Угтамын лам нарыг зүгээр байлгадаггүй. Хурал ном хурж байхад нь орж ирээд гэхдээ биеэрээ орж ирдэггүй. Янз бүрийн амьтны дүртэй болж ирээд. Хурал номыг үймүүлээд байдаг байжээ. Тэгсэн нэг өдөр Довчин хувилгаан ан авд унадаг хар морио унаж ирээд хийдийнхээ хашаанд 3 хоног сойжээ. Та энэ морио сойдог нь яаж байгаа юм бэ гэсэн. За би үүгээр нэг зүйлд бэлдэж байна аа л гээд байсан. Тэгсэн нөгөө бөө Довчин хувилгаанд хүчээ үзье. Хэн нь илүү гэдгээ харъя гэсэн байжээ. Цаад бөө нь ч айхтар. Үнсэн дээр хөрвөөгөөд чоно болоод хувирчихдаг. Гэрийнхээ тооноор шувуу болоод нисээд гарчихдаг тийм бөө байжээ. Довчин хувилгаан За урдаас тоос гарахыг нь хараарай л гээд байсан. Тэгсэн шавь нар нь бүрээнийхээ цамхагт гарч харж байгаад Багш аа! тоос гарлаа гэжээ. Тоос хийдээс өнгөрөөд Довчин хувилгаан тэрний араас морио унаад л давхисан. Хойд дээр лам зүүн талд бөө баруун талд уулзаж гэнэ. Бороо орохгүй хэрнээ тэнгэр дуугараад хар үүл хуралдаад л аянга цахилгаан нижигнээд байж. Нэлээд удаж гэнэ. Тэгж байснаа гэнэт тэнгэр цэлмэхээр нь хувилгааны шавь нар очсон чинь нөгөө бөө чинь татчихсан байна гэнэ. Хамаг цус нь юүлэгдчихсэн. Бөв бөөрөнхий болчихсон өршөөл эрж байна гэнэ. Бөө их баян хүн байсан. Бүх юмаа хийдэд өргөөд өөрөө Бурханы шашинд орсон гэдэг. Довчин хувилгаан бөө дарсан газраа суварга босгоод үүнээс хойш миний шавь нар хар хүчинд бүү дийлдэх болтугай гэж ерөөсөн гэдэг.

Угтам бол хийдийнхээ хувьд Монголд 4-рт, цамаараа 1-рт ордог байсан. Цамын багийг уран Наваан гэдэг хүн хийсэн. Цамын баг, дэгээрээ их гоё байсан юм гэсэн. Цам гарахаар бороо ордог. Тэгэнгүүт Шагдар хувилгааныг дуудна. Шагдар хувилгаан гэж 7,8 насны үсээ урт ургуулсан бороо оруулдаггүй хүү байж. Чи энэ бороог зогсоох уу үгүй юу гээд зандардаг гэнэ. Тэгэхлээр тэр хүү гүйж гараад баруун хойшоо болон зүүн хойшоо хараад үсээ зулгааж шатаагаад шороо цацдаг байж. Тэгэнгүүт тэнгэр цэлмээд хайш хайшаа км хэртэй газар орохгүй тойроод л ороод байдаг байж. Шагдар хувилгаан хийдийн сүүлчийн хувилгаан гэж ярьдаг л даа. Тэгээд Шагдар хувилгаан чинь хойноос гал ороод ирнэ. Хийдийнхээ хойно нь гарч байгаад л ном уншихна. Тэгэхээр хийдийг тойроод хуваагдаад л явчихдаг байсан гэсэн.

Цагаантнууд хойноос орж ирсэн гэнэ. Замд таарсан бүхнийг сүйтгэж дээрэмдээд. Дамбадаржаагийн хийдийг сүйтгээд Угтамд орж ирэх гэсэн. Тэгэнгүүт хойд зүг рүү хараад л салтайгаараа шороо цацчихсан гэсэн. Тэгээд л хүүхдүүдтэй тоглоод гүйж явсан. Тэгсэн манан буусан. Зэрэгцсэн хоёр хүн бие биенийгээ харахгүй төөрсөн тийм их манан буусан. Цагаантнууд тэр их мананд Угтамыг тойроод явчихсан гэж ярьдаг.

Хийдэд гүйдэг Даржаа гэдэг газар товчилдог хүн байсан гэдэг. Нэг лам нь туршсан байгаа юм. Чи гүйдэг гүйдэг л гэх юм. Луус хөлөглөдөг л гэх юм. Үнэнч юм уу, худлаа ч юм уу хэн мэдлээ гэжээ. Даржаа үзэхгүй юу чи гэсэн. Нөгөө хүн хүрээ орохдоо зориуд айлд хөөргөө орхиод нэг хүн ирж авна. Авангуут тэр өдрийг тэмдэглээд

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

авчихаарай гэсэн. Тэгээд буцаж ирснийхээ дараа Даржаатай таарсан. Даржаа хаа хүрэх гэж явна гэхэд Богдын хүрээ орох гэж явна гэхээр нь мартсан юмаа захъя гэсэн. Даржаа ч аа тэг тэг гэж байна гэнэ. Би тийм тийм айлд хөөргөө орихчихсон юм. Багшийн минь хөөрөг тэргийг л нэг авчирч өг гэжээ. Даржаа Өө тэр амархан өөр юу захих вэ гэж байна гэнэ. За хэзээ явах гэж байгаа гэсэн. Одоо явлаа. Хэзээ ирэх юм гэсэнд өнөөдөр эргээд ирнэ л гэж байна гэнэ. Нөгөө лам хуралдаа хүрчихаад ирсэн Даржаа гэрийнх нь гадаа сууж байна гэнэ. За сайн яваад ирэв үү, захисан юм авчирав уу гэхэд Даржаа тэр айлыг чинь олох гэж нэлээд зүдэрлээ гэж байна гэнэ. Тэгэхээр нөгөө лам дотроо за энэ ч худлаа хэлэх нь дээ гэсэн шүү юм бодож гэнэ. Тэгсэн Даржаа за май хөөргөө гээд гаргаад өгсөн гэдэг. Ер нь манай Угтамын хамба лам нар хувилгаадүүд Даржааг Хүрээ рүү бичиг захидал хүргүүлэх яаралтай ажилдаа явуулдаг байсан юм гэнэ лээ. Даржаа хуралд хурдаггүй тийм нэг лам байсан юм гэсэн.